

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

ТОГТМОЛ ХЭВЛЭЛД ГАЗРЫН БАЯЛГИЙН АСУУДЛЫГ ТУСГАСАН ЗАРИМ НИЙТЛЭЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

М.Наранчимэг*

*“Улаанбаатар Эрдэм” ИС-ийн Сэтгүүл зүй, олон улс судлалын тэнхимийн багш,
МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: оршин тогтнохуй, үзэл баримтлал, үндсэн хууль, газар шороо, газрын харилцаа, үндэсний аюулгүй байдал, асуудал дэвшүүлсэн өгүүлэл.

Монгол Улсын Үндсэн хуулийн дөрөвдүгээр зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Монгол Улсын хилийг хуулиар бататгана” гэж заасан бол “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн” хэмээн заажээ. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийнхаа бүрэн бүтэн, хилийнхээ халдашгүй дархан байдал, хүн амынхаа удмын сан, соёл иргэншлээ хамгаалан үлдэхэд Монгол хүн бүрийн хичээл зүтгэл, оюун ухаан, хувь нэмэр чухал гэдэг нь өнөөдөр ч улам бүр батлагдсаар байна.

2010 онд “Үндэсний аюулгүй байдлын тухай үзэл баримтлал”-ыг шинэчлэн баталж, аюулгүй байдалд хандах хандлага, шийдвэрлэх арга замуудыг шинээр томъёолж Монгол Улсын “Оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “Эдийн засгийн аюулгүй байдал”, “Дотоод аюулгүй байдал”, “Хүний аюулгүй байдал”, “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “Мэдээллийн аюулгүй байдал” зэрэг нь харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажна” гэдгийг онцлон тодоройлжээ. Энэ нь тууштай хэрэгжиж байгаа эсэх нь өнөөдөр тодорхойгүй байна.

Тиймээс энэхүү амин чухал сэдвийг Монголын тогтмол хэвлэлд яаж, ямар арга хэлбэрээр тусгаж буйг судалж, алдаа оноог илрүүлэх зорилгоор “Ардын эрх”, “Хөх тэнгэр”, “Өнөөдөр”, “Үнэн” сонины нийтлэлд дүн шинжилгээ хийлээ.

Газар нутгийн аюулгүй байдал түүхийн туршид аль ч үндэстний тэмцлийн гол утга учир байсаар ирсэн билээ. Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулах чиглэлд хөрш хоёр улстайгаа хилийн дээсийг нягтлан, хоёр, гурван талт гэрээг зохих журмаар байгуулан

баталгаажуулсан баримт цөөнгүй. Амьдрах орон зайн төлөө тэмцэл овог аймаг үүсэн бий болсон цагаас өнөөг хүртэл тасралтгүй үргэлжилж хүн төрөлхтний мянга мянган жилийн тэмцэл тулаан зөвхөн амьдрах орон зайгаар хэмжигдэж байлаа. Амьдрах орон зай гэдэг маань хүний хувьд юуны өмнө газар юм. Газар гэдэг маань Эх орон юм. Үндэстэн оршин тогтноно гэдэг юуны өмнө газар нутагтай байхын нэр. Улс орон гэдэг ч газар нутаг гэсэн ойлголтоос эхэлнэ. Эцэг дээдэс минь үе үеэрээ шингэсэн тэр газрыг Эх орон гэж ариунаар нэрлэн дуудаж, “Хүнээс аваагүй миний нутаг, хүнд өгөхгүй ганцхан нутаг” гэж амь хайрлахгүй тэмцэн ирсэн учиртай.

Дэлхий дахинд аугаа их задрал явагдаж, нэгдмэл байсан улс орнууд тархай бутархай болж байна. Өнөөдөр амьдрах орон зайгаа тэлэхийн төлөө тэмцэл дэлхий дахинд урьд байгаагүй хүчтэй өрнөж, Израйль, Палестин хоёр газрын төлөө мөнхийн маргаантай, Чечень, Орос хоёр цус урсган тулалдаж, Боснийн серб, хорватууд хэдэн жил алалцаж, Парсалийн арал Хятад, Вьетнам хоёрын хоолойд тээглэсэн яс болж, хойт, өмнөд хоёр Солонгос бие биеэ отоож, Канадаас Квебекүүд салан тусгаарлахаар тэмцэж, Англи, Ирланд хоёр муудалцаж, Армен, Азарбайжан хоёр ч үе үе энд тэндээ хүрч, Фолклендын арлуудыг Аргентин, Англи хоёр булаалдаж, Турк, Грек хоёр Эгейн арлаас болж муудалцаж байна. Ирак, Кувейт хоёр дайсагнаж, Хятад Тайвань руу санаархаж, Курилын арлуудаас болж Орос, Япон хоёр маргалдаж, Тажик, Афган хоёр ч хилийн зөрчил буудалцаан тасрахгүй, Энэтхэг ч Кашмирын салан тусгаарлагчдаас болж амар заяа үзэхгүй зовсоор...¹.

Дэлхий дахинд амьдрах орон зайгаа тэлэхийн төлөө, газраа тэлэхийн төлөө тэмцэл эхэлж, харин Монголд амьдрах орон зайгаа танах, газраа худалдах үйлс эхлэв. “Миний газар нутгийг бурхан гуйсан ч битгий өг” хэмээн Галдан Бошигт хаан нэгэнтээ захин үлдээжээ. Чин ван Ханддорж, Сайн ноён хан Намнансүрэн, Да лам Цэрэнчимэд яагаад бусдад хорлогдов? Газар нутгаа та бидэнд үлдээх гэж...

Өнөөдөр хуулийн цоорхойгоор Монгол Улсын тусгаар тогтнол, монгол үндэстний аюулгүй байдлын “Баталгаа” элсэн цаг шиг урссаар л байна. Монголын тусгаар тогтнолд аюултай “Тэнэг хууль” батлагдах гэж байна. Сэрэгтүн, залуус аа!”² хэмээн яруу найрагч О.Дашбалбар тэртээ 1997 онд нэгэн сонинд бичиж байжээ.

2002 оны 6-р сарын 27-нд Монгол Улсын иргэнд хувийн хэрэгцээнд, аж ахуйн зориулалтаар гэсэн 2 хэлбэрээр газрыг өмчлүүлэх хууль батлагдсан. Энэ хуулийн 1.1-д “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заасан байдаг.

1991 онд “Үндсэн хуулийн төслийг олон түмнээр хэлэлцсэн байдал ч газрын өмчлөлийн асуудлыг ард иргэдээс ирсэн олон арван захидлын тоймыг авч үзэхэд газрыг хувьд өмчлүүлэх саналыг 23-хан хүн дэмжиж, харин газрыг төрийн өмчид байлгаж, иргэдэд эзэмшүүлэх саналыг 4426 хүн дэмжсэнээ илэрхийлжээ. Гэтэл тэр үеийн АИХ-ын чуулган хэдхэн хүний хүсэл сонирхолд автаж, дээрх хуулийг баталсныг тухайн үед олон хүн эсэргүүцэж байсныг сонины хуудсанд үлдсэн дараах бичвэрүүдээс харж болно. Нэрт яруу найрагч О.Дашбалбар: “Газрыг зөвхөн Монгол

Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж Үндсэн хуулинд заасан нь тэр үед ард нийтийн санал бодлыг “ардчилагчид” гэгчид үл тоомсорлосны гэрч болж түүхэнд үлдэнэ” гэсэн бол хуульч Ц.Шаравдорж “Газрыг хувьд өмчлүүлэх санаа нь газрын хэвлий, ус, ой, ан амьтан, ургамал зэрэг нь ард түмний мэдэлд байна” гэсэн Үндсэн хуулийн заалттай агуулгын хувьд зөрчилдөж байна” гэжээ.

“**М**онголын нутаг дэвсгэрийн 70 гаруй хувийг бэлчээр, 10 орчим хувийг ой мод, 6 орчим хувийг тариалан, хадлан бэлчээр, тариаланд тохиромж бүхий газар эзэлж байна... Газрын хуулийг мал сүргээ өсгөх, баялгаа ашиглах, урамшуулах хөшүүрэг болгохоосоо урьд, татварын орлого талыг нь өнгөцхөн харсан, торгууль, төлбөр, түрээсийн объект болгох вий гэдэгт л санаа зовж байна” гэж дэд доктор Ч.Ширчин 1994 онд “Ардын эрх” сонинд бичсэн бол мөн сонинд Завхан аймгийн ХАА-н биржийн захирал Д.Дагвадорж “Монгол орны хувьд өвөлжөө бэлчээрийг хувьд өгөх нь малаар тоглох гэсэнтэй адил үг” хэмээн хэлжээ. Түүхийн ухааны доктор Г.Сүхбаатар агсан “Оройн дээд шүтээн минь Монгол Улсын тусгаар тогтнол” хэмээх ярилцлагадаа “...Зарим нэг улс төрийн хүчний буруу бодлогын харгайгаар манай улсын тусгаар тогтнолд аюул учраад байна. Ер нь шуудхан хэлэхэд Манжийн дарангуйлал сэргэж эхэлж байгаа шүү гэдгийг түс тас хэлчихэд буруудахгүй. Хил хязгаар маань цоорхой сав шиг болчихжээ” гэдгийг онцлон хэлж байжээ.

Түүхэн сурвалжуудаас үзэхэд газрыг Монголчууд хувьдаа өмчилж байсангүй. Энэ тухай академич

Ишжамц, Далай, доктор А.Жамсран, Д.Гонгор, Г.Сүхбаатар нарын бүтээл, тэрчлэн “Нууц товчоо” зэрэг алтан сурвалжид ч монголчууд газрыг хувьд өмчлүүлж байгаагүйг тэмдэглэжээ.

“Үнэн” сонины 1994.11.22-ны өдрийн дугаарт нийтлэгдсэн 1000 шахам хүнийг хамруулж хийсэн судалгаанд оролцогчдын 46 хувь нь газрыг төрийн мэдэлд байлгах, 16 хувь нь хувьд өмчлүүлэх чиглэл баримталж, 38 хувь нь байр сууриа илэрхийлээгүй байна. Дээрх судалгаанд оролцогчдын 74 хувь нь газар өмчлүүлэх асуудлыг бүх ард түмний санал асуулгаар шийдэх нь зүйтэй гэж үзжээ. “Үндэсний-хээ түүхэн уламжлалаас гажиж, газрыг хувьд өмчлүүлж болохгүй” гэсэн саналыг тэр үеийн УИХ-д олон эрдэмтэн саналаа оруулсаны үр дүнд тухайн үеийн УИХ-аар газар өмчлөх асуудал дэмжигдээгүй юм. Харин “Ардчилсан холбоо” эвсэл засгийн эрхэнд дөнгөж гармагцаа “газрыг иргэдэд өмчлүүлэх” ажлыг цаг нь болоогүй, нөхцөл байдал бүрдээгүй байхад дахин хөндөж 75.9 хувийн саналаар УИХ түүнийг нь дэмжин баталсан байдаг.

“Өнөөдөр” сонин 2015 оны №083-д “Газрын зориулалтыг судлахаар боллоо” мэдээ нийтлэгдсэн байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт газар ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамж гаргаж, аж ахуйн нэгж, байгууллагуудын эзэмшиж, ашиглаж буй газрын зориулалт “Газар зохион байгуулалт, газар ашиглалтын бүсчлэл”-д нийцэж буй эсэхийг судлахыг нийслэлийн засаг дарга нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, өмчийн харилцааны газарт даалгасан тухай мэдээлжээ. Энэ нь “Газар өмчлөл”-ийн хуультай холбогдож, нийслэл аж ахуйн

байгууллагууддаа хяналт хийж буй чухал ажлын талаар мэдээлэл хүргэсэн өгөөжтэй нийтлэл болжээ.

“Өдрийн сонин”-ы 2015 оны №067-д Засгийн газрын 2015 оны 3-р сарын 11-ны хуралдаанаар “Алтны ордыг нэмэгдүүлж эдийн засгийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын төслийг хэлэлцэн баталсантай холбогдуулан Уул уурхайн яамны төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан байгуулагдсан ажлын хэсгийн үр дүнг уул уурхайн сайд засгийн газрын хуралдаанд танилцуулга хийсэн тухай нийтэлжээ. Энэ ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгах журмын төсөл болон гэрээний загварыг боловсруулсан тухай мэдээлсэн байна. Мөн Засгийн газрын 2014 оны 239 дүгээр тогтоолоор нийт газар нутгийн 19.9 хувьд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ба үүний 13,4% буюу 20,9 сая га талбайд өргөдлөөр, 6,5% буюу 10,2 сая га талбайд сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгохоор зохицуулсан тухай мэдээлжээ.

Энэ нийтлэл Засгийн газрын хуралдааны талаарх мэдээлэл төдий байсан бөгөөд мэдээллийн мөрөөр сэтгүүлч эрэл хайгуул хийж, цувралаар нийтлэл бичиж, дээр өгүүлсэн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт болон өргөдлийн мөрөөр дахин сурвалжлага хийж, мэдээллийг уншигч олонд ашигтай өгөөжтэй мэдээлэл болгож хүргэх талаар учир дутагдалтай болжээ. Тус сонины “Улс төр” буланд

нийтлэгдсэн УИХ-ын гишүүн Г.Баярсайхантай хийсэн “АН, МАН хамтарсан засаг барьж буйн үр шимийг Таван толгойн төсөл дээр харуулах ёстой” ярилцлагад “Ноён уул”-ыг төрийн хамгаалалтад авах тухай хуулийн төсөл өргөн барьсан. Энэ нь улс төрчид популизм хийх сэдэв гэж ойлгож болох уу?” гэсэн сэтгүүлчийн асуултанд “Манайд Ардын нам энэ үйл ажиллагааг эхлүүлсэн. Би бол Ноён уулын олон жилийн түүхтэй тэндээс олон гол горхи ихтэй, өвгөдийн булш бунхан зэргийг төрийн хамгаалалтад авах хэрэгтэй учир хуулийн төсөл өргөн барьсан” гэжээ. Энэ ярилцлагын зорилго, ач холбогдол тодорхой бус уншигч түмэнд өгөөж бага, сонины зай бөглөсөн гарчигтай тохироогүй сул ярилцлага болжээ.

“Өдрийн сонин”-ны 2015 оны №074-д “Баримт, үзэл бодол” буланд сэтгүүлч Б.Цэнддоогийн “XXI зууны Монгол Тоглоомын Улсаас Тоглоомон Улс” гарчигтай 2 нүүр томоохон материал нийтлэгджээ. “Ноён уулын ноёны эрэл”, “Дайсан олдвол нөхөр олдоно”, “Дайсангүйдэн тарсан Монгол Улс”, “Эргэж ирсэн XIII зуун”, “Тусгаар тогтнолыг унагая гэвэл эдийн засгийг унага”, “Түр засгийн газар буюу иргэний хөдөлгөөн”, “Монголыг доороос нь удирдахуй”, “Аньж эхэлсэн АЛТАН боломж”, “Эцсийн буюу боломжгүй шахам боломж” гэсэн хэсгүүдэд Монгол Улсын хувь заяа хаана явна вэ? Монголын төрийн голлох шийдвэрийг хэн гаргадаг вэ? гэх мэт олон асуултын хариултыг эрж хайсан байна. Мөн “Ноён уул” болон бусад улс төр, эдийн засгийн ноёлох шийдвэрийг гаргасан процедурыг ажиглахад Монголын хөгжлийн өнөөгийн байдал тусгаар тогтнолын ирээдүйг шинжихэд харамсал-

тай дүр төрх харагдаж байна гэж дүгнэсэн байна. Учир нь Ноён уулаас жишээлээд Монголын эдийн засаг, улс төрийн асуудлыг шийдэх гарцыг заадаг ноён нь ард түмэн үү? Төр үү? Эсэргүүцлийн цуглаан хөдөлгөөн үү? Эсвэл цаанаас удирддаг өөр хүчин байна уу? гэж асуугаад монголчуудын түүхийг сөхвөл дотоод эрх ашгийнхаа төлөө нэгдэж, хөгжлийн гарцаа тодорхойлж явсан түүх нэн ховор бололтой гэжээ. “Тусгаар тогтнолыг нь унагая гэвэл эдийн засгийг нь унага” гэсэн үг байдаг. Нам намаараа, фракци бүлэглэлээрээ хагаралдан “орондоо унтах завгүй хагаралдан, хөнжилдөө унтах завгүй намчирхах” болов гэж өнөөгийн Монголын улс төрийн тогтворгүй байдлыг тодорхойлжээ. Монголчууд улс төрийн талаар тусгаар байхыг ярьдаг боловч эдийн засгаар тусгаар тогтнох алхам бүрийг гар нийлэн нураана. Монгол төрийн чадамжгүй байдлыг далимдуулан хөрш орнууд тоглолт хийж байна. Эрх баригч намд улс орноо хөгжүүлэх, эдийн засгийн дорвитой тогтвортой шийдвэр гаргах боломжийг хайхаас илүү гарсан боломжоо ашиглаж, сөргөлдөгч намаа дарахын тулд хөрөнгө завших, луйвардах, авлигадах байдал газар авсан гэсэн гаргалгаа хийсэн байна.

“Түр засгийн газар буюу иргэний хөдөлгөөн” хэмээх хэсэгт эрчим хүчний хувьд бусдаас хараат бус байх алхам хийхэд энэ талын том төсөл, хөрөнгө оруулалтыг болиулах, зогсоох асуудалд иргэний хөдөлгөөнүүд оролцож, Монголын албан бус хамгийн хүчирхэг төр болж, ялангуяа эдийн засгийн тусгаар тогтнолтой холбоотой шийдвэрийг мөхөөдөг байна. Өнөөдөр Монголын төр гудманд гарч “явуул”-ын, “нүүдэл”-ийн түр засгийн газрын гарт орсон

байна. Нүүдлийн түр засгийн газар нь ихэнхдээ байгаль хамгаалах хэмээх нэрэн дор энэ салбарыг онилж, Монгол Барууны хөрөнгө оруулалт орох гарцыг хааж, гадаад бодлогодоо тунхагласан гурав дахь хөршийн сонирхлыг боож, Монгол эдийн засгийн хувьд тусгаар тогтнох боломжийг олгохгүй, улмаар Монгол Улс эдийн засгийн тусгаар тогтнолын эсрэг үндэсний хөдөлгөөнийг ашиглаж, XXI зуунд ардчилсан тогтоц, нийтлэг араншинд нь таарулан, Монголын төрийг дороос нь удирдаж, хүссэн шийдвэрээ гаргуулж буй юм биш биз? Сонирхогч 2 хөршийн бидний үндэсний онцлог дээр тоглолт хийж байна уу? “Ноён уулаа аварья” хөдөлгөөн бол эх орноо гэсэн иргэд, авлигач засгийн газрын тулалдаан биш, Орос-Хятадын сонирхол, Барууны хөрөнгө оруулагчдын сонирхол зөрчилдсөн гэж үзжээ. Канадын “Сентерра гоулд” компаний гадаа жагсаал хийж, Монголд орж ирсэн Францын хөрөнгө оруулагчдыг хөөх процесс, Монголын стратегийн түүхий эд болох ураныг Орос, Хятадаас өөр улс оронд өгөх өгөхгүйн асуудлаарх том гүрнүүдийн барилдаанд монголчууд бие биеэ хэмнэлж байгаа юм ямар вэ дээ? гэсэн асуултаар энэ бүлгээ төгсгөсөн байна.

Дээрх нийтлэл Монголын өнөөгийн төр засгийн бодлого шийдвэр, улс орны тусгаар тогтнол, газар нутгийн аюулгүй байдлын талаар Монгол Улсыг удирдаж буй улс төрчдийн нүүр царай, чадамжгүй байдлыг илтгэн харуулсан үнэнийг өгүүлэн жишээ баримтаар баталгаажуулан бичсэн дорвитой бүтээл болсон байна.

“Өдрийн сонин” 2015 оны №074-д Уул уурхайн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Түмэнбаяртай хийсэн “Ашигт

малтмалын хайгуулын зөвшөөрлийг зөвшөөрөгдсөн бүсэд олгож эхэлсэн” нэртэй ярилцлага нийтлэгдсэн байна. Энэ ярилцлага нь мэдээллийн багтаамж сайтай, төрийн бодлогын түвшинд хийгдэж буй ажлууд, эдийн засгийн тулгуур болсон уул уурхайн салбар төрөөс “Эрдэс баялгийн талаар баримтлах бодлого”-ыг боловсруулж, УИХ-аар батлуулсан, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг төрөөс зөвшөөрөгдсөн газар нутагт олгож, ашигт малтмалын нөөцийг олон улсын стандартын дагуу тогтоох “KRECKO” олон улсын байгууллагын гишүүнээр элссэн, ашигт малтмалын тухай хуулийн 5-р зүйлд стратегийн ач холбогдол бүхий ордуудын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг тогтоох асуудлыг хуульчлан баталсан тухай, хайгуулын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр өргөдлийн дугаараар өгөх болсон тухай мэдээлжээ.

2015 оны 3-р сарын 13-ны “Өнөөдөр” сонинд “15 жилийн өмнө ухсан Гацууртыг одоо эсэргүүцэхийн учир юунд вэ?” гарчигтай сэтгүүлч Д.Оюун-Эрдэнийн нийтлэлд маргаан дагуулаад байгаа “Гацуурт”-ын ойролцоо шинэ орд биш Хүннүгийн үеийн булшийг хөндөх нь нэрээр лицензтэй компанийг цуцалж, дураар нинжа нараар ухуулж алтыг нь олборлох гэсэн хүмүүсийн үйлдэл гэж үзжээ. Учир нь Гацууртын олборлолт хийх газарт түүхийн ямар ч олдвор байхгүй аж. Баримт сөхвөл 1991 онд Гацууртын шороон ордыг илрүүлж, “Гурван гол”, “Гацуурт” компани 1992-2000 онд олборлолт хийж, 1998 онд Каскадиа компани Гацууртын үндсэн ордыг нээж, хайгуул судалгааны ажил хийж нөөцийг баталгаажуулжээ. Гацууртын орд нь Сэлэнгэ аймгийн Мандал суманд, харин Хүннүгийн булш нь Мандал сум

болон Төв аймгийн Борнуур сумын заагт оршдгийг сэтгүүлч кадастрын зургаар тодорхой харуулж баримтад тулгуурлаж уг нийтлэлээ бичсэн байна. Ингэхдээ төр хууль ёсны лицензтэй компанийг хориглож, нинжа нар өөрсдөө Хөвсгөлийн Улаан тайгын алтыг өдөр шөнөгүй хэдхэн сарын турш өвөл зунгүй цөлмөсөн түүх давтагдах вий гэж сэрэмжлүүлжээ.

2015 оны 3-р сарын 31-ны №076-д “Өнөөдөр” сонинд “Хятадын “Бэлтрэг суйлах” амбийц ба Монгол” нэртэй өгүүлэл нийтлэгджээ. Уг нийтлэлд өмнөд хөршид үйлдсэн дэлхийн газрын зургийн заримд Монголыг зориуд мартсан байдаг талаар дурдаад өдгөө “Дэлхийг хятадчиллах түрэмгий бодлого” идэвхжиж, Азийн орнууд болон алс холын Африкийн улсууд хүртэл түүний нөлөөнд автаж юаниар арилжаа хийх боллоо гэж бичсэн байна. Хятад эдийн засгийн хувьд төдийгүй улс төрийн нөлөөллөөрөө Америктай өрсөлдөх хэмжээнд ирсэн нь тоогүй. Хятадын төрийн тэргүүн Си Зиньпин очсон газар бүртээ өндөр дүнтэй өр зээлийг санал болгож цаагуураа доллар, юанийн өрсөлдөөн идэвхжиж буйг нотлох шиг. БНХАУ дэлхийн 29 оронд 3.1 их наядаас хол давсан юанийг своп хэлцэл нэрээр зээлүүлээд байгаа. Сайхан сэтгэлээр тусалсныхаа төлөө юу нэхэх вэ?

Африк хүртэл гар сунгаад амжсан өмнөд хөрш монголчуудад ямар сонголт үлдээсэн нь сонин. Өнөөдрийн байдлаар гадаад өр 1.4 тэрбум доллар түүнээс Хятадын ардын банкнаас зээлээ 15 тэрбум юань хүртэл нэмсэн байна. Өрөндөө нүүрс нийлүүлдэг. Тавантолгойн хэлэлцээр Сү.Батболдын үед 20 жилийн хугацаатай тавьсан өрнөөс болоод зогсчихсон

байгаа. Тавантолгой Хятадын “Chalco”, “China Shenhua energy” хоёр компанийн мэдэлд очсон. Таван толгойн асуудлыг Бээжинд шийдэх нь бараг тодорхой болчихлоо. Ар халхын эрдэс баялгийн орд газруудын тавиланг Бээжинд нь дэнслэх нь гэж халаглан бичсэн байна. Өнөөдөр зөвхөн тусгаар хилтэй, тусдаа хэлтэй байснаараа улс орон оршин тогтнодоггүй гэдгийг дэлхий даяар эхэлчихээд буй колоничлолын шинэ эрин үе сануулж буй хэмээн энд бас дурьдан сэрэмжлүүлжээ.

Энэ сонины нийтлэлээс өнөөдөр Монгол орны газар шороо, эрдэс баялаг, эдийн засгийн аюулгүй байдал ямар байдалтай байгааг харж болно. Эх орноо гэсэн чин сэтгэлтэй сэтгүүлч өөрийн үүргээ гүйцэтгэж, хөдлөшгүй үнэн баримтаар жишээ татаж энэ нийтлэлээ бичжээ. Эндээс эх орон газар шороо үр хойчоо элгэн түмнээ гэсэн сэтгэлтэй улс төрчид, улс орны төлөө шийдвэр гаргах түвшинд Монгол орны хувь заяаг гартаа атгаж буй хэн бүхэн ухаарал, сэрэмж авах хэрэгтэй юм.

“Өнөөдөр” сонины 2015 оны №070-д “96 саяар үнэлэгдэх алт эх орондоо үлдэж, эзэн бүсгүй ялтан болов” гарчигтай нийтлэл гарчээ. Нийтлэл эхлэхдээ монголчууд эртнээс л алт хар мөртэй алтаар баяждаггүй хэмээн ярьдаг. “Алт” хөтөлбөр хэрэгжээд баяжвал баяжих цаг боллоо улс орны эдийн засаг сайжирсан юм алга харин ч дордож элгээрээ хэвтэхэд хүрээд байна. Мөн Монгол орны минь онгон дагшин байгалийг алт олборлогч нэртэй нам нийлж сэм хоршсон хүмүүс, “нинжа” нэртэй хүн оготнууд сүйрүүлсээр. Монгол орны баялаг хямд үнээр харийханд очиж, өндөр үнээр буцаан авч байна. Хил гааль тагнуулын

байгууллагынхан бишгүй л үйлдлийг таслан зогсоож, улс орны эдийн засагт учрах байсан их хэмжээний хохирлоос урьдчилан сэргийлж байдгийн нэг жишээг энэ нийтлэлд хөндсөн байна. Эх орны минь алтан хэвлийг онгичиж буйг нэгэн баримтаар жишээлж улс орны газар дорх баялаг үнэгүйдэж, эдийн засаг хямарч буйг сануулж бичсэн нийтлэл байна.

“Өнөөдөр” сонины 2015 оны №064-д тоймч Т.Энхбатын “Зэрэглээн дундах Тавантолгой” хэмээх нийтлэл хэвлэгджээ. Тавантолгойн ордоос Хятадын “Чалко” компанид урт хугацаагаар нүүрс нийлүүлэхээр нууц гэрээ хийж, “Эрдэнэс Таван толгой” компани 350 сая ам. доллар авсан байна. Мөн өрөө төлсний дараа Тавантолгойн Зүүн Цанхиас олборлосон нүүрсний 80 хувийг таван жилийн турш худалдана, мөн төдий хугацаанд 60 хувийг нь нийлүүлнэ гэж заасан аж. Хэрэв манай тал үүргээ биелүүлэхгүй бол нөхөн олговор төлж, арбитрт дуудагдах нарийн заалт ч байгаа гэнэ. Энэ гэрээгээр нийт 10 жил нүүрс нийлүүлэх үүрэг хүлээсэн хэрэг. Тавантолгойн орд улс төрчдийн популист санаануудын золиос болж буй нь үнэн гэж сэтгүүлч шууд хэлсэн байна. Тавантолгойн ордын хэвлийд 6 тэрбум тонн нүүрсний нөөц бодитоор бий, гэвч хэзээ ашгаа өгөх нь монголчуудын үүсгэсэн зэрэглэнд сүүмийж байна хэмээн нийтлэлээ төгсгөжээ. Энэхүү нийтлэл нь Тавантолгойн хувь заяа монгол түмний баялгийг зөв хувиарлаагүйгээс хэсэг бүлэг хүний увиагүй үзэл бодлоос болж, алт нь авдарт байсаар байтал арга нь мухардсан аятай буруу явдлаас болж буцахдаа шороо тээхийн үлгэр болсныг тоймч үнэнээр нь дэлгэн гаргасан байна. Энэ мэт төрийн бодлого алсын хараагүй цөөн улс

төрчөөс болж Монгол орны газар шороо түүний дорх баялаг харийн орны барьцаанд орох аюул нүүрлээд буйг ХМХ-д ажиллаж, “дөрөв дэх” засаглалын үүргийг гүйцэтгэж буй сэтгүүлч ил тод үнэнээр мэдээлсэн нь сайшаалтай.

“Өнөөдөр” сонины 2015 оны №099-д “Эрдэнэс Тавантолгой” 23.2 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ” нийтлэлд эдийн засгийн эргэлтэд бүрэн ороогүй дэлхийн коксжих нүүрсний томоохон ордод Тавантолгойн уурхай ордог. “Эрдэнэс Тавантолгой” 5.8 сая тонн нүүрс өнгөрсөн жил экспортолсон нь дотоодын нүүрсний компаниудыг борлуулалтын хэмжээгээрээ тэргүүлж, 400.7 тэрбум төгрөгөөр хар алт борлуулсан тухай мэдээлжээ. Уг нийтлэлээс харахад улстөрийн увайгүй үйлдлээс болоод Монгол орны эдийн засгийг аваад явчих уул уурхайн баялгаа эдийн засгийн эргэлтэд зөв зарчмаар шийдэж чадахгүй зогсонги байдалд оруулсан нь илт байна. Өнөөгийн Монгол орны өмнөөс шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй улс төрчид улс орныг монгол түмнийг ядуу байлгах сонирхол байна уу гэсэн хардлага төрөхөд хүргэж байна.

“Өнөөдөр” сонины 2015 оны №096-д “Эрдэнэс Таван толгой”-н зээл Хөгжлийн банкиг хөлдөө чирэх нь” нийтлэлийг сэтгүүлч Д.Оюун-Эрдэнэ бичжээ. Уг нийтлэлд газар нутгийнхаа бараг гуравны хоёрт хар алттай монголчууд Таван толгойгоо зөв ашиглаад эхэлчихвэл хэдэн үеэрээ эдийн засгийн хүндрэлгүй аж төрөх боломжтой. Баялгийн үүцээ нээхдээ эрдэс баялгийн салбар дахь нэгдсэн бодлогоо алдсанаас Монголын нүүрсний орд үнэ цэнэ, ашиг орлого, борлуулалт, тээвэрлэлт нь өдөр шөнө шиг ялгаатай ажиллаж байна. Энэ үзүүлэлтийг

“Эрдэнэс Тавантолгой” болон “Энержи Ресурс” компанийн 2014 оны өртгийн үндсэн үзүүлэлтийг харьцуулсан байна. Энэ харьцуулалтаар “Эрдэнэс Тавантолгой” нэг тонн нүүрс олборлохдоо 26.2 ам.доллор зарцуулдаг бол “Энержи Ресурс” 19.7 ам доллар үүний зөрүү 6.5 ам доллар буюу 33 хувийн илүү зардлаар тонн нүүрс олборложээ. 2014 оны статистик мэдээнээс харахад “Эрдэнэс Тавантолгой” Цанхийн уурхайд 14.261 сая шоо метр хөрс хуулжээ, “Энержи Ресурс” Ухаа худгийн уурхайд 26.264 сая шоо метр хөрс хуулжээ. Үүнээс харахад “Энержи Ресурс” хоёр дахин илүү хөрс хуулж нэг тонн нүүрс гаргаж авсан байна. Тээвэрлэлтийн хувьд ч багагүй зөрөө харгадаж байгаа юм. “Эрдэнэс Тавантолгой” 17.5 ам.доллар, “Энержи Ресурс” 14.1 ам.доллар. Яг адилхан зайд 3.4 ам доллар илүү зардаг байна.

Үүнээс харахад Улсын хөрөнгөөр олборлолт хийж буй компани болох “Эрдэнэс Тавантолгой” өрөнд орж, зардлаа хэмнэх нь бүү хэл илүү зардал гарснаар тайландаа тусгасан байх юм. Эндээс ард түмний дунд яригдаад амны уншлага болох шахсан “Төрөөс төрсөн тэрбумтан” гэгч хэлц үг биеллээ олдог юм байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

Дээрх сонинуудын газрын тухай нийтлэлүүдэд дүн шинжилгээ хийхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл үүргээ гүйцэтгэж олон талын баримтад тулгуурлан тухайн үйл явдлыг тоочин үнэний араас эрэл хайгуул хийж, сониноор дамжуулан олон түмэндээ хүргэсэн байна.

Дүгнэлт. Газар нутгийн аюулгүй байдлын тухайд түүхийн туршид аль ч үндэстний тэмцлийн гол утга учир байсаар ирсэн, өнөөдөр ч тулгамдсан асуудлын нэг байсаар байна. Монгол

газар нутаг маань дотроосоо өтөх адил газрын наймааны уршгаар бүрэн бүтэн байдал нь алдагдаж байна гэж дүгнэхэд хүргэлээ. Улс орон гэдэг ч газар нутаг гэсэн ойлголтоос эхэлнэ. Эцэг дээдсийн минь буян шингэсэн газар нутаг, Эх орноо хүн бүр хайрлан хамгаалах цаг иржээ.

1992-2000 оны хэвлэл мэдээлэлд тухайлбал “Үнэн”, “Монгол тамга”, “Ардын эрх”, “Хөх тэнгэр” сонинуудад газар өмчлөлтэй холбоотой, газрыг хувьд өмчлөхийн эсрэг иргэдийн болоод, мэргэжилтнүүд, УИХ-ын гишүүдийн дуу хоолойг сониноор дамжуулан олон түмэнд тодорхой нээлттэй судалгаатай хүргэж, ОНМХ-ийн үүргээ амжилттай биелүүлж байсан байна. Улс орны өмнө тулгамдсан аливаа асуудлыг сэтгүүлч мэдээлээд зогсохгүй мэдээллийн мөрөөр эрэл хайгуул хийж, цувралаар нийтлэл бичиж, олон түмэнд ашигтай ажил үйл болгоход өөрийн дуу хоолойг төрд хүргэх хүртэл даацтай нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, дахин дахин сурвалжлага хийж, мэдээллийг уншигч олонд ашигтай өгөөжтэй мэдээлэл болгож хүргэх шаардлага өнөөдөр хэрэгтэй байна. Учир нь сэтгүүлч мэдээллийг дамжуулаад зогсохгүй тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, нийгэмд үр ашигтай ажил болгоход нөлөөлөх нь өнөөдөр чухал байгаа юм.

Ишлэл

¹ Дашбалбар О. Газрын төлөө жинхэнэ тулалдаан эхэллээ! // “Хөх тэнгэр”. 1997 он 1-р сар.

² Мөн тэнд.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009-2010. Монголд чөлөөт ардчисан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Боть I-V. УБ.
2. Зулькафиль М. 2015-2017. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть I-X. УБ.
3. Машбат О. Оршин тогтнохуйн аюулгүй байдал Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд //, “Стратеги судлал” сэтгүүл, (2011, №5
4. Норовсүрэн Л. 2004-2007. Монголын нийтлэл. Боть I-III. УБ.
5. Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1994.
6. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.
7. Монгол Улсын “ Газар өмчлүүлэх тухай хууль”.
8. “Ардын эрх” сонины 1992-2000 оны дугаарууд.
9. “Монгол тамга” сонины 1992-2000 оны дугаарууд.
10. “Өнөөдөр” сонины 1992-2000 оны дугаарууд.
11. “Хөх тэнгэр” сонины 1992-2000 оны дугаарууд.

Резюме

В данной статье автор исследует формы подачи и мастерство публикаций, освещающих земельные проблемы в газетах “Ардын эрх”, “Өнөөдөр”, “Хөх тэнгэр”, “Монгол тамга” (1992-2000 гг). Автор опираясь на многочисленные фактические материалы и правовые акты, которые регулируют вопросы земельных отношений делает вывод о том, что газеты этого периода успешно и многосторонне освещали любые проблемы, связанные с земельными отношениями и стали трибуной гласности и плюрализма по данным вопросам.